

## НИЙТЛЭЛ

## ХКН-ын XVIII их хурлаас хойших Хятад улсын гадаад бодлогын шинэ үзэл санаа ба Монгол, Хятадын харилцаа

**Тэрбишийн Чулуун-Эрдэнэ**

Доктор Ph.D, хятад судлаач, багш,  
Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Монгол Улс  
[chuluunerdene.t@gmail.com](mailto:chuluunerdene.t@gmail.com);

*Хураангуй:* 2012 онд ХКН-ын XVIII их хурал хуралдаж, Ши Жиньпин засгийн эрх барьснаар Хятад улсад гадаад харилцааны шинэ үзэл санаа бүрэлдэн тогтоож, тус улс цаашид өөрийн онцлог бүхий их гүрний гадаад бодлого баримтлах болно гэдгээ зарласан билээ. Ши Жиньпин-ээр төвлөсөн Хятадын төрийн удирдлагын гадаад бодлогын шинэ стратеги нэгд, их гүрний шинэ маягийн харилцааг бий болгохыг эрмэлзэж буй. Хоёрт, Хятад улс хөрш улс орнууд хоорондын гадаад харилцаанд өндөр ач холбогдол өгч буй. Гуравт, хамтран ажиллах, хамтдаа хожих хамтын ажиллагааг гол болгосон олон улсын шинэ маягийн харилцааг байгуулахыг эрмэлзэж буй зэрэг онцлогтой байна. Энэхүү өгүүлэлд ХКН-ын XVIII их хурлаас хойших Хятад улсын гадаад бодлогын шинэ үзэл санаа, тэр дундаа хөрш зэргэлдээ улс орнуудад хандан хэрэгжүүлж буй “Ойр дотно, чин сэтгэлийн, харилцан ашигтай, уужуу хүртээмжтэй байх” ба “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” хэмээх гадаад бодлогын ойлголтын талаар танилцуулж, 2012-2021 онд Монгол, Хятад хоёр улсын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд болсон үйл явдал, тэр дундаа аюулт цар тахлын эсрэг хамтдаа тэмцсэн хийгээд хоёр талын харилцан бие биедээ тусалж дэмжиж ирсэн түүхүүдийг өгүүлнэ.

*Түлхүүр үгс:* Хятад улсын гадаад бодлого, Ши Жиньпин, XVIII их хурал, хувь заяаны цогц нэгдэл, Монгол, Хятадын харилцаа



## Оршил

Монгол, Хятад хоёр улс олон мянган жил хаяа дэрлэн оршиж ирсэн мөнхийн хөршүүд билээ. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг<sup>1</sup>-ийн хэлсэнчлэн өнөөдөр манай хоёр улсын харилцаа "түүхэн дэх хамгийн таатай үед ирж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа шинэ үе шатанд орсон" гэж хэлж болохоор байна.

Хятад улс түүхийн урт хугацаанд Дэн Сяопин-ий дэвшүүлсэн "даруу байж, хүчээ нөөх" (韬光养晦) стратегийн үзэл баримтлалыг гадаад харилцааны үндсэн жолоодлого болгон, тууштай баримталж ирсэн юм. Гэвч сүүлийн жилүүдэд олон улсын нөхцөл байдал улам нарийн төвөгтэй болж, даяаршил газар авч буй зэрэг хүчин зүйлсийн нөлөө Хятадын гадаад харилцааны бодлогод гүн гүнзгий нэвтэрч, тусгалаа олж, Хятад улсыг цаг үеийн нөхцөл байдалд тохирсон гадаад харилцааны бодлогын шинэчлэлт хийхэд хүргэсэн байна. Чингээд 2012

оны 11 дүгээр сард ХКН-ын XVIII их хурал хуралдаж, Ши Жиньпин засгийн эрх барьснаар Хятад улсад гадаад харилцааны шинэ үзэл санаа бүрэлдэн тогтож, тус улс цаашид өөрийн онцлог бүхий их гүрний гадаад бодлоготой байна гэдгээ онцлов. Ши Жиньпин дарга дотоод, гадаад хоёр их төлөв байдалд зэрэг анхаарч, "Хятадын мөрөөдөл"-ийн дэлхий дахины ач холбогдлыг олон улсад тайлбарлан илэрхийлэхэд төвлөрч ажиллах, мөн хамтдаа хожих явдлыг гол цөм болгосон олон улсын шинэ маягийн харилцааг байгуулна гэдгээ ч зарласан юм. Түүнчлэн Хятад улс хөрш зэргэлдээ орнуудтайгаа гадаад харилцаагаа идэвхтэй эрчимжүүлж, хөрш орнуудтайгаа "Ойр дотно, чин сэтгэлийн, харилцан ашигтай, уужуу хүртээмжтэй байх" (亲、诚、惠、容) ба "Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл" (人类命运共同体)-ийг бүрдүүлэхээ илэрхийлсэн.

### Нэг. ХКН-ын XVIII их хурлаас хойших Хятад улсын гадаад бодлогын шинэ үзэл санаа

БНХАУ байгуулагдсанаас хойш Хятад улсын гадаад бодлогыг үечилбэл: Нэгдүгээрт, Шинэ Хятад улс байгуулагдаж, энх тайвнаар зэрэгцэн оршиход анхаарч эхэлсэн үе. Хоёрдугаарт, өөрчлөлт шинэчлэлт нээлттэй бодлого хэрэгжүүлэн, энх тайванчаар хөгжиж, өөрчлөлт шинэчлэлтийг бодлогын манлайд

тавьсан үе. Гуравдугаарт, ХКН-ын XVIII их хурлаас хойш хамтдаа хожсон хамтын ажиллагааг эрхэмлэх болсон үе. Энэ нь Ши Жиньпин-ий гадаад бодлогын хүрээнд "Хоёр бүтээн байгуулалт" (两个构建) гэж нэрлэгдэж буй "Олон улсын шинэ маягийн харилцааг бүтээн байгуулах", "Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл"-

1 Б.Батцэцэг: Монгол, Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн таатай үедээ байна, <https://www.montsame.mn/mn/read/202084>

ийг бүтээн байгуулах” гэсэн цөм бодлогуудыг агуулдаг байна<sup>2</sup>.

Хятад улс 2003 оноос хөрш улс орнуудад “сайн хөрш байх, сайн түнш байх” гадаад харилцааны бодлогыг баримталж, олон улсын тогтолцоонд “Зохиролт дэлхий” үзэл баримтлалыг дэвшүүлэхийн зэрэгцээ олон талт механизмаар дамжуулан, харилцан ашигтай, хамтран ажиллах, хэлэлцэн зөвшилцөх замаар төрөл бүрийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхийн чухалтайг онцолсоор ирэв. Энэхүү “Зохиролт дэлхий” үзэл баримтлалын үндсэн төлөвлөлт доор Хятад улс хөрш зэргэлдээ улс орнууддаа “сайн хөршийн гадаад харилцаа”-г удирдлага болгосон бодлогыг авч хэрэгжүүлж, чиг бодлогын хувьд юуны өмнө “энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим” (тусгаар тогтнол бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтлох, дотоод хэрэгт харилцан үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших)-аас эхэлж, Хятад улсын эдийн засгийг сайжруулахад тустай энх тайван олон улсын орчныг бүрдүүлэх; дараа нь “бүс нутгийн хамтын ажиллагааны таван зарчим” (харилцан хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай, харилцан нээлттэй байх, хамтдаа цэцэглэн хөгжих, харилцан зөвшилцөж нэгдмэл ойлголтод хүрэх)-ыг баримталж, асуудлыг түр хойш нь тавих нөхцөл доор түүхийн улбаатай үлдсэн асуудлыг хэлэлцэн зөвшилцөж

шийдвэрлэх; эцэст нь бүс нутгийн нэгдлийг зангидах явдлыг дэмжих, “их гүрнийг тэргүүнд тавьж, хөрш зэргэлдээ орнуудыг голлох” үндэс болгож, Зүүн Азийг манлайлах байр сууриа бэхжүүлэх бодлого баримтлан<sup>3</sup> ажилласан байна.

Харин Хятад улсын дарга Ши Жиньпин-ээр төвлөсөн Хятадын төрийн удирдлага нь дэлхий дахины өнцгөөс их гүрний (Хятад улсыг хэлж байна) үүрэг хариуцлагыг өндөрт тавих ёстой болохыг олонтаа онцлон тэмдэглэж, дотоод гадаадад тавьсан илтгэлүүдийн агуулгад “хувь заяаны цогц нэгдэл”, “даян дэлхийн түншлэлийн харилцаа”, “даян дэлхийг удирдан засах тогтолцооны өөрчлөлт шинэчлэлтийг удирдан, оролцох”, “шинэ маягийн олон улсын харилцаанд хамтран ажиллаж, хамтдаа ялах” зэрэг үгс олонтаа хэрэглэгдэж байгаагаас даяаршлын үйл явц, үзэл санаа Хятадын гадаад харилцааны бодлогод ямархан гүн гүнзгий нөлөөлж буйг, мөн Хятадын шинэ Засгийн газрын гадаад харилцааны бодлогын ерөнхий чиглэлийг харах боломжтой юм.

Онцлон дурдууштай нь хөрш орнуудын гадаад харилцааны ажлын уулзалтууд дээр, “Хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл”-ийг дэвшүүлэхийн зэрэгцээ, Ши Жиньпин дарга 2013 оны 10 дугаар сард АСЕАН-ы улс орнуудад айлчлах үеэрээ “21-р зууны далайн торгоны зам”-ыг бүтээн байгуулах талаар дэвшүүлж, мөн 9 дүгээр сард Төв Азид

2 中国特色大国外交展现大国担当,

[https://www.chinanews.com.cn/gn/2021/05-29/9488240.shtml?utm\\_source=pocket\\_mylist/](https://www.chinanews.com.cn/gn/2021/05-29/9488240.shtml?utm_source=pocket_mylist/)

3 Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, Ай Эс Ди Рүби паблишинг, УБ 2019 он, Удам Соёл хэвлэлийн газар

айлчлах үедээ “Торгоны замын эдийн засгийн бүс” буюу “Бүс ба зам”-ыг дэвшүүлсэн юм. “Бүс ба зам” нь Хятад улсын “Хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл”-ийг цогцлоох бодит бодлого болов. Нэмж тодруулахад 2014 онд ХКН-ын Эдийн засгийн ажлын хуралдаан дээр “Бүс ба зам” санаачилгыг улсын стратегийн түвшинд ахиулан дэвшүүлж, 2016 онд “Бүс ба зам санаачилга” болон түүний цөм үзэл санаа НҮБ-ын хурлын тогтоолд, мөн Их 20 болон АПЕК зэрэг бусад бүс нутгийн байгууллагуудын үндсэн баримт бичигт албан ёсоор бичигдсэн нь хэрэгжилтийг түргэтгэхэд нөлөөлсөн байна. 2017 оны ХКН-ын XIX их хуралд “Бүс ба зам” санаачилгыг намынхаа дүрэмд оруулав. Энэ бүгдээс харахад урьдын зарим гадаад бодлоготой адилгүй нь энэ удаагийн “Бүс ба зам” нь тус улсын стратеги болтлоо хурдацтайгаар өссөнөөр зогсохгүй, мөн Хятадын хөрш орнуудын хийгээд дотоодын холбогдох салбаруудын хэрэгжилтийг түргэтгэх Хятад улсын Засгийн газрын эрчимтэй төлөвлөлт болсныг харуулж байна.

Ерөнхий сайд Ли Көчян 2014 оны 3 дугаар сарын 5-ны өдөр Засгийн газрын ажлын илтгэлдээ сайтар төлөвлөж, “Торгоны замын эдийн засгийн бүс” болон “21-р зууны далайн торгоны зам”-ыг бүтээн байгуулах хэрэгтэй хэмээн тодотгосон нь “Бүс ба зам” нь хэдийнээ Хятадын төрийн

стратеги болсныг илтгэж байна<sup>4</sup>. Мөн Ши Жиньпин ХКН-ын XVIII удаагийн ТХ-ны V бүгд хурлын II удаагийн бүгд хуралдаан<sup>5</sup> дээр “Бүс ба зам”-ын бүтээн байгуулалт нь тус улсын гадаадад нээлттэй байдлыг өргөжүүлэх стратегийн нэгэн чухал арга хэмжээ, эдийн засгийн гадаад харилцааны дээд түвшний төлөвлөлт гэж үзээд, олон талт худалдааны тогтолцоог сахин хамгаалж, чөлөөт худалдааны бүсийн стратегийн хэрэгжилтийг хурдасган, өөрийн улсын хүчин чадавх, байр сууринд нийцсэн олон улсын хариуцлага, үүргийг идэвхтэй хүлээх ёстой” гэж цохон тэмдэглэв.

Түүнчлэн хүн төрөлхтний нийтлэг дайсан Covid-19 цар тахалтай тэмцэх явцад Хятад улс “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” үзэл санаагаа тууштай баримталж, Ши Жиньпин дарга 2020 оны 3 дугаар сард хүн төрөлхтний эрүүл мэндийн нэгдлийг бий болгох санаачилгыг дэвшүүлсэн нь Хятад улсын цар тахлын эсрэг дэлхий нийтийн хамтын ажиллагаанд оролцохдоо баримтлах чиглэлийг тодорхойлж<sup>6</sup>, цар тахалтай тэмцэх Хятад улсын үүрэг хариуцлага, олон улстай хамтран ажиллах үйл ажиллагааг харуулав.

Энэ бүгдээс Ши Жиньпин-ээр төвлөсөн Хятадын төрийн удирдлагын гадаад бодлогын шинэ стратеги нь хэд хэдэн онцлогтой болох нь харагдаж байна. Үүнд, юуны өмнө, Хятад улс их гүрний шинэ маягийн харилцааг бий

4 Шюй Липин, Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: бүтээхүй хийгээд арга зам. Ай Эс Ди Рүби Паблшинг, Орчуулсан Т.Чулуун-Эрдэнэ, 2020 он, Соёмбо принтинг.

5 Ши Жиньпин, Төр улсыг засахуй II, Ардын Хэвлэлийн хороо, Бээжин хот, 2019 он.

6 Хятад, Монгол хоёр улс сэргэн мандалтын замд хатуу хүтүүг хамтран давна, <http://itoim.mn/article/uROQt/29777/>

болгохыг эрмэлзэж буй. Энэ нь тус улс хамтын, цогц, тогтвортой аюулгүй байдлын үзлийг санаачилж, их гүрний шинэ маягийн харилцааг байгуулан, олон шинэ санаа, санаачилгаар дамжуулан дэлхийн хэмжээний асуудалд бие даан, санаачилгатай оролцож, дэлхийн хөгжилд өөрийн орны хувь нэмрийг оруулах үйл ажиллагааг явуулж буйгаар илэрч байна. Хоёрт, Хятад улс хөрш улс орнууд хоорондын гадаад харилцаанд

өндөр ач холбогдол өгөх болов. Энэ нь “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” хэмээх шинэ ойлголт дэвшүүлэн, “Ойр дотно, чин сэтгэлийн, харилцан ашигтай, уужуу хүртээмжтэй байх” хөрш орны бодлого баримталж буйгаар харагдаж байна. Гуравт, хамтран ажиллах, хамтдаа хожих хамтын ажиллагааг гол болгосон олон улсын шинэ маягийн харилцааг байгуулсан зэрэг болно.

### Хоёр. Хувь заяаны цогц нэгдэл ойлголтын тухай

“Хувь заяаны цогц нэгдэл” нь сүүлийн жилүүдэд ялангуяа Ши Жиньпин Хятадын дээд удирдагчийн тушаалд орсноос хойш Хятад улсын зүгээс ихээхэн хүчин чармайлт гарган дэвшүүлж буй олон улсын асуудлыг удирдан засах лугаа холбоотой шинэ ойлголт бөгөөд улс төрийн хүрээний халуун сэдэв, Хятадын гадаад харилцааны гол цөм ойлголт хэдийн болоод байна.

Хятадын эрдэмтэд хувь заяаны цогц нэгдлийн талаар өөр өөрийн тодорхойлолтыг дэвшүүлсэн байдаг. Миний 2020 онд орчуулж гаргасан Хятадын олон улс судлалын эрдэмтэн Лью Шипин-ий “Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: Бүтээхүй хийгээд арга зам” хэмээх судалгааны бүтээлд тус ойлголтыг аливаа улс орон хатуу бэрхийг хамтдаа туулах харилцаагаар өөр зуураа холбогдох явдал юм. Үүнд зөвхөн эдийн засгаас гадна нийгэм, хүмүүнлэг, үнэт зүйл, аюулгүй

байдлын цогц нэгдэл ч багтана гэсэн бол эрдэмтэн Хань Юймин: “Хүн төрөлхтний цогц нэгдэл” гэдэг нь хүн төрөлхтөн хамтдаа нүүр тулж буй даян дэлхийн нарийн төвөгтэй асуудлыг хамтдаа сөрж, шийдвэрлэхийн тулд санаачилгатайгаар бий болгосон харилцан хамааралтай, салгахын аргагүй, жаргал зовлонгоо хамтатган орших нэгэн шинэ хэлбэрийн харилцаа юм<sup>7</sup> хэмээжээ.

Хятадын Ардын их сургуулийн профессор Ван Ивэй: “Хятад улсын хувьд хөрш зэргэлдээ эргэн тойрон гэдэг нь аюулгүй байдлын амин чухал газар, цэцэглэн хөгжих үндэс суурь болсон газар юм. Иргэний нийгэмтэй холбоотой түүхэн үзэл баримтлалд үндэслэн “Бүс ба зам” нь соёл иргэншлийн цогц нэгдлийн үзэл баримтлалд суурилан, даяаршил, Евразийн интеграцын стратегийн дагуу Хятадын эргэн тойрны их орчинд эрх ашиг, үүрэг хариуцлага, аюулгүй байдлын цогц нэгдлийг төлөвшүүлэн,

7 Denghua Zhang, The Concept of ‘Community of Common Destiny’ in China’s Diplomacy: Meaning, Motives and Implications, 2017, Received: 30 October 2017 | Revised: 25 January 2018

эцэстээ хувь заяаны цогц нэгдлийг бүтээн байгуулах замаар Хятадын олон улс дахь нөлөө, зөөлөн хүчийг нэмэгдүүлэх болно<sup>8</sup> хэмээн Хятадын гадаад улс орнуудтай харилцах бодлого стратегийг маш тод томруун өгүүлсэн байдаг.

“Хувь заяаны цогц нэгдэл” санаачилгыг дэвшүүлэхэд хүргэсэн үндсэн хоёр хөшүүрэг бий хэмээн Хятадын эрдэмтэд хардаг. Үүнд: “Нэгд, богино хугацаанд энэхүү ойлголтоор дамжуулан, Хятадын Засгийн газар хөрш орнуудтайгаа Өмнөд Хятадын Тэнгис дэх газар нутгийн маргаантай асуудлыг намжаан, холбогдох улс орнуудтай гадаад харилцаагаа зөөлрүүлэх; хоёрт, 21-р зууны эхний 20-30 жил буюу Хятадын “стратегийн боломжит үе” (机遇期)-дээ энэхүү санаачлагыг чиг баримжаа хийн, гадаад харилцааны стратегиа сайтар хэрэгжүүлж, Хятадын эдийн засгийн хөгжилд гадаад харилцааны таатай орчныг бий болгохыг эрмэлзэх<sup>9</sup> явдал юм. Энэхүү хөшүүргийг ашиглан, Хятад улс хөрш зэргэлдээ улс орнуудын дэмжлэгийг авахын тулд улс орнуудтай маш хүчирхэг, хамтын эрх ашиг цогцолсон зангилааг бий болгохоор чармайж байна. Тиймээс ч хүчирхэг эдийн засаг, бодит чадамждаа тулгаарлан, Хятад улс хөрш зэргэлдээ түнш орнууддаа эдийн засгийн таатай

боломжуудыг илт санал болгосоор байгаа юм. “Бүс ба зам” санаачлагын хүрээнд олон улс орнууд Хятад улсаас мөнгөн зээл тусламж авч, дэд бүтэц болон бусад салбарын хөгжилд зарцуулдаг. Үүнийг АНУ тэргүүтэй Өрнөдийн улс орнууд Хятад улс эдийн засгийн тусламжаар дамжуулан, улс орнуудыг өрийн дарамтад оруулж, эдийн засгийн хэт хамааралд оруулж байна хэмээн шүүмжлэлтэй ханддаг. Мөн Дэлхийн банк, Олон улсын вальютын сангаас Хятад улсыг “Бүс ба зам” санаачлагын хүрээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын хэмжээ болон зээлийг олон нийтэд нээлттэй байлгахыг шаарддаг. Ямартаа ч “Бүс ба зам” санаачилга дэвшүүлснээс хойших 7 жилийн хугацаанд хийгдсэн ажлуудаас дурдвал: Хятад улс 2013-2020 оны хооронд нийт 171 улс орон болон олон улсын байгууллагатай “Бүс ба зам”-ыг хамтдаа бүтээх хамтын ажиллагааны 205 бичиг баримтад гарын үсэг зуржээ.<sup>10</sup> Мөн “Бүс ба зам” санаачилга нь зам дагуух улс орнуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсныг Дэлхийн банкны судалгаанд “Бүс ба зам” санаачлагын хүрээнд холбогдох улс орнуудын 7,6 сая хүнийг нэн ядуу буурай байдлаас, 32 сая хүнийг дунд түвшний ядуурлаас ангижруулж чадсан<sup>11</sup> хэмээх тоон үзүүлэлт баталж байна. Мөн Америкийн Аж ахуйн

8 Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, Ай Эс Ди Рүби публичинг, УБ 2019 он, тал 55, Удам Соёл хэвлэлийн газар

9 Denghua Zhang, The Concept of ‘Community of Common Destiny’ in China’s Diplomacy: Meaning, Motives and Implications, 2017, Received: 30 October 2017 | Revised: 25 January 2018

10 疫情下 一带一路 “五通” 逆风前行,

<http://www.chinatradenews.com.cn/content/202103/18/c129269.html>

11 白皮书: 共建 “一带一路” 使相关国家760万人摆脱极端贫,

<http://fec.mofcom.gov.cn/article/fwydy1/zgzx/202104/20210403051302.shtml>

байгууллагын нийтийн бодлогын институт (The American Enterprise Institute for Public Policy Research)-аас гаргасан тоон мэдээллээр 2014 оноос 2020 он хүртэл Хятад улс “Бүс ба зам” төсөлд хөрш зэргэлдээ орнуудын сэргээгдэх эрчим хүчний салбарт хийсэн хөрөнгө оруулалт ихээхэн хэмжээгээр буюу 40%-иар өсчээ гэсэн

судалгаа гаргажээ.<sup>12</sup>

Дүгнэвээс, Ши Жиньпин засгийн эрхэнд гарснаас хойш гадаад харилцаандаа идэвхтэй, санаачилгатай нээлттэй байх стратегийг илүүтэй баримталж, гадагшаа хандсан хөгжлийн тал дээр “Хувь заяаны цогц нэгдэл” үзэл баримтлалыг бодлогын гол шугам болгож байна.

### Гурав. ХКН-ын XVIII их хурлаас хойших Монгол, Хятадын харилцаа

БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл юм<sup>13</sup>. Монгол, Хятад хоёр улс 1949 онд албан ёсоор дипломат харилцаа тогтоосноос хойш иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоож хөгжүүлэх хүртэл, нийгэм, эдийн засаг, хүмүүнлэг, соёлын солилцоо зэрэг олон чиглэлд харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр ирэв.

2014 оны 8 дугаар сарын 21-ний өдөр БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, хоёр тал “Стратегийн түншлэлийн харилцаа”-гаа “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа” болгон ахиулж чадсан юм. Ийнхүү Хятад улсын дарга 11 жилийн дараа Монгол Улсад дахин айлчилсан нь тус улсын хөрш зэргэлдээ орнууд хоорондын гадаад харилцааг

чухалчилан байгаагийн бодитой жишээ болсон билээ.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Тяньжин хотод Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгтэй уулзахдаа “Монгол Улс Хятад улстай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл болгосныг үнэлж байна... Шинэ нөхцөл байдалд Хятад улс Монгол Улстай хамтаар хүчин чармайлт гаргаж, анхдагч сэтгэлээр урагшилж, Хятад, Монголын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд шинэ агуулга, шинэ хөдөлгөгч хүч нэмж, хоёр орны ард түмэнд илүү их ашиг тус авчирч, бүс нутгийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах болно”<sup>14</sup> хэмээн онцлон тэмдэглэж, мөн “Хятадын тал өөрийн боломжийн хэрээр Монгол Улсын хөгжлийг түргэтгэхэд туслах бөгөөд Монголын

12 Хятад улс “Нэг бүс нэг зам” санаачилга дэвшүүлэх болсон түүхэн нөхцөл, бодлогын шийдвэр ба хэрэгжилт,

<http://www.mglnews.mn/content/read/82025.htm?fbclid=IwAR3Is9obCYohGb6kaHNo8a9nblqPXa-DRlWCBdRUUyvRWoWBZDaWM6Vx3Urg>

13 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, <https://mfa.gov.mn/trade/61577>

14 2021年7月28日外交部发言人赵立坚主持例行记者会,

[https://www.fmprc.gov.cn/web/wjdt\\_674879/zcjd/202107/t20210728\\_9180743.shtml](https://www.fmprc.gov.cn/web/wjdt_674879/zcjd/202107/t20210728_9180743.shtml)

талтай уул уурхай, эрчим хүч, санхүү, хөдөө аж ахуй, дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэг олон салбарын хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхэд бэлэн байгаа” гэдгээ илэрхийлсэн юм. Түүнчлэн талууд хоёр талын худалдааны эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилт дэвшүүлсэн байдаг<sup>15</sup>. 2021 оны эхний 8 дугаар сарын байдлаар, Монгол, Хятад хоёр орны гадаад худалдааны нийт эргэлт 6.8 тэрбум ам.доллар хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54.5%-иар өссөн ба Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 67.3%-ийг эзэлж байна. Энэ бол хоёр улс хамтран хичээсний үр дүн гэж болно<sup>16</sup>.

2019 онд Монгол Улс ба БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, хоёр орны хооронд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулсны 25 жилийн ой тохиож, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпин-ий урилгаар Хятад улсад төрийн айлчлал хийн, хоёр улс “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл”-ийг бүтээхэд хамтдаа чармайж, хоёр улсын харилцааг улам урагшлуулна гэдгээ бататгасан юм.

Хоёр улсын худалдаа, эдийн засгийн салбар нь бие биенээ нөхөх давуу талтай ба хамтран ажиллах орон зай, нөөц бололцоо ихтэй<sup>17</sup>. Ши Жиньпин дарга 2014 оны 9 дүгээр сард Монгол, Хятад, Оросын төрийн тэргүүн нарын анхдугаар

удаагийн дээд хэмжээний уулзалтад оролцох үедээ “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг Оросын Ази, Европыг дамнасан их төмөр зам болон Монголын “Талын зам” санаачилгатай уялдуулж, “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ыг бүтээн байгуулах тухай санал дэвшүүлж, холбогдох хөтөлбөрийг баталсан нь хоёр улсын төдийгүй, бүс нутаг, дэлхийн эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах чухал ач холбогдолтой үйл явдал болсон билээ.

2019 оноос дэлхий дахинд Covid-19 цар тахал дэлгэрснээр бөмбөрцгийн улс орон бүрт урьд өмнө байгаагүй хүнд цохилтыг өгч, дэлхий даяар тогтворгүй, тодорхойгүй, эмх замбараагүй байдалд татагдан орж, дэлхий бүхэлдээ өөрчлөлт шинэчлэлтийн шинэ давалгаанд шилжлээ. Энэ амаргүй нөхцөлд Монгол, Хятад хоёр улс халдварын эсрэг гар нийлэн хүч нэгдэж тэмцсэн сайхан түүхийг бүтээсэн юм. Монголчууд “Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусалсан нь дээр”, “Айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг” ч гэдэг. Монголын ард түмэн, аж ахуйн нэгжүүд Ү хань хотын ард иргэдийн цар тахалтай тэмцэхэд нь зориулж сайн дурын санаачилгаар сэтгэлийн хандив цуглуулж, Хятадын талд хандивласны зэрэгцээ, Монголын Засгийн газраас санаачлан 30 мянган толгой хонь бэлэглэсэн юм. Монголчууд халуун хошуут мал—хонийг бэлэг бэлгийн

15 Монгол Улс дипломат харилцааны боломж бүрийг ашиглаж байна, <https://gogo.mn/r/q0o47>

16 Хятад, Монгол хоёр улс сэргэн мандалтын замд хатуу хүтүүг хамтран давна, <http://itoim.mn/article/uROQt/29777/>

17 Монгол, Хятадын харилцаа таагай үедээ хөгжиж байна, <https://news.mn/r/2418520/>



дээд хэмээн үзэж дээдэлдэг бөгөөд чин сэтгэлийн илэрхийлэл болгодог. Уг бэлэг нь Монголын ард түмэн, Хятадын ард түмний гүн зузаан уламжлалт найрамдал нөхөрлөлийн илэрхийлэл болсон юм. Харин Монгол Улсаас Хятадын ард түмэнд цар тахлын тусламж болгон хүргүүлсэн 30 мянган хонины хариу болгож, Хубэй мужийн Ардын Засгийн газраас PCR оношлогооны 3 төхөөрөмж, 30 мянган оношлуур тест болон цай бэлэглэв<sup>18</sup>. Мөн Хятад улсын Засгийн газраас 300 мянган хүн тун вакциныг Монгол Улсад хандивласан билээ. Хятад улсаас **Монгол Улсад суугаа Элчин сайд Цай Вэньруй-н хэлсэнчлэн** “Цар тахлын сорилтын өмнө, хоёр улс харилцан ойлголцох, дэмжих зарчмаар хамтран ажиллаж, “хонины хариуд цай” барьсан сайхан түүх хоёр улсын найрсаг харилцааны түүхэнд бичигдэн, хоёр улсын ард түмний харилцааг шинэ оргил өөд тасралтгүй ахиулж<sup>19</sup>, Монгол, Хятадын харилцаа, найрамдал нөхөрлөл улам зузаарсаар байна.

Хятадын зүгээс “Шинэ эрин үеийн Хятадын олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа” цагаан ном (新时代的中国国际发展合作白皮书)<sup>20</sup>-нд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд сүүлийн жилүүдэд буцалтгүй тусламжаар Монгол Улсад бодитой хэрэгжүүлсэн төслүүдээс дурдвал:

Нэгд, Хятадын Засгийн газар Монгол Улсад «Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв»-ийг байгуулан, 2019 онд Монгол Улсын Засгийн газарт хүлээлгэн өгөв; Хоёрт, Мазаалай баавгайн амьдрах орчныг сайжруулах төслийн техник, эдийн засгийн үнэлгээний судалгааны ажлын уулзалтын протоколд гарын үсэг зурах ёслол Улаанбаатар хотод болж, Улаанбаатараас 1000 гаруй км-ийн зайд орших мазаалай тархан амьдардаг говийн дархан цаазат бүсийн 18 мянган ам дөрвөлжин км бүхий нутагт хээрийн шинжилгээ хийн, чухал тоо баримтуудыг цуглуулж төслийн хэрэгжилтэд маш сайн суурь тавьж өгсөн<sup>21</sup>. Гуравт, 2016 онд Хятадын 1 сая ам долларын буцалтгүй тусламжаар “Монгол Хятадын хамтарсан молекул биологийн хэрэглээний лаборатори” байгуулагдав. Цаашлаад Хятад улсын Засгийн газрын хөнгөлтэй зээлээр Улаанбаатар-Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал чиглэлийн 32.2 км хурдны зам болон Яармагийн гүүрийг ашиглалтад оруулсан; Улаанбаатар-Мандалговийн 330 квт-ын 250 км урт цахилгаан дамжуулах шугам, хоёр дэд станцыг байгуулан хүлээлгэн өгсөн. Эдгээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад монголын залуус Хятадын технологи

18 30 мянган хонины хариуд Хубэй мужаас PCR оношлогооны төхөөрөмж, оношлуур бэлэглэв, / <https://gogo.mn/r/dkgnn/>

19 Хятад, Монгол хоёр улс сэргэн мандалтын замд хатуу хүтүүг хамтран давна, /<http://itoim.mn/article/uROQt/29777/>

20 新时代的中国国际发展合作白皮书(全文), /<http://www.scio.gov.cn/zfbps/32832/Document/1696685/1696685.htm/>

21 БНХАУ-ын Засгийн газрын тусламжаар хэрэгжүүлэх Мазаалай баавгайн төслийн ажлын уулзалтын протоколд гарын үсэг зурлаа, /[http://mn.china-embassy.org/mn/zmgx/201610/t20161012\\_1661457.htm/](http://mn.china-embassy.org/mn/zmgx/201610/t20161012_1661457.htm/)

болон ажлын туршлагаас суралцаж, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлж чадлаа. Энэ бүгдээс харахад Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагаа нь хөрш орнууд хоорондын “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл”-ийн үндсэн

үзэл санааг бодитойгоор хэрэгжүүлж, хоёр орны хөгжлийн стратегийг урагшлуулж, хоёр улсын харилцааны хөгжлийг улам ахиулж байгаа дүр зураг тодорч байна.

### Дүгнэлт

“Хувь заяаны цогц нэгдэл”-ийг дэвшүүлсэн нь “Хятадын мөрөөдөл”-ийг биелүүлэх, Хятад улсын дүр төрхийг сайжруулах лугаа нягт холбоотой, мөн Хятадыг “хариуцлагатай их гүрэн”-ий дүр төрхийг бүрдүүлэн, хамгаалахад ихээхэн тустай болохын зэрэгцээ энэ ойлголт өнөөдөр хэдийнээ шинэ цаг үеийн Хятадын гадаад харилцааны бодлогын онол болон практикийн шинэчлэлийг чиглүүлэгч, түүнчлэн Хятад улс хөрш орнуудтай харилцах стратегиа боловсруулах чухал арга нь болжээ гэж дүгнэхээр байна.

ХКН-ын XVIII их хурлаас хойш буюу Ши Жиньпин засгийн эрх барьснаас хойш Хятадын хөгжил шинэ үе шатанд шилжиж, тус улс гадаад бодлогын онол, практикийн шинэчлэлийн шинэ үе шатанд алхан орсон юм. Хятад улсын зүгээс дэвшүүлсэн “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” бол улс орнуудыг өөр өөрийн нөхцөл байдалд тохирсон хөгжлийн стратегийг баримтлан,

хамтдаа хөгжиж, хамтдаа хожихыг уриалдаг. Энэ нь Хятад улсын дэвшүүлсэн олон улсын шинэ маягийн харилцааг бий болгох онолын үндэс суурь гэж болно. Монгол, Хятадын харилцаа ч мөн хоёр талын эрх ашигт тулгуурласан, харилцан ашигтай байх зарчмын дагуу урагшилж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятад хоёр улсын төрийн өндөр дээд хэмжээний айлчлалын давтамж ихсэж, үүнийг даган хоёр орны улс төрийн итгэлцэл нэмэгдэж, иргэд хоорондын харилцаа нягтарч, нийгмийн олон салбарын хамтын ажиллагаа улам эрчимжиж, энэ нь Монгол, Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн сайн үедээ ирсэнийг илтгэж байна. Түүнчлэн Хятад улс “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл”-ийг бүтээн байгуулах ажилд төвлөрч, чармайн урагшилж байгаа нь Монгол, Хятад хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг ахиулахад онцгой ач холбогдолтой болох нь тодорхой юм.

## Ашигласан материал

### Ном:

1. Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, Ай Эс Ди Рүби Пабблишинг, 2019 он, Удам соёл хэвлэлийн газар.
2. Шюй Липин, Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: бүтээхүй хийгээд арга зам. Ай Эс Ди Рүби Пабблишинг, Орчуулсан Т.Чулуун-Эрдэнэ, 2020 он, Соёмбо принтинг.
3. Ши Жиньпин, Төр улсыг засахуй II, Ардын Хэвлэлийн хороо, Бээжин хот, 2019 он.

### Эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Denghua Zhang, The Concept of ‘Community of Common Destiny’ in China’s Diplomacy: Meaning, Motives and Implications, 2017, Received: 30 October 2017 | Revised: 25 January 2018

### Цахим мэдээ мэдээлэл:

1. Б.Батцэцэг: Монгол, Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн таатай үедээ байна, <https://www.montsame.mn/mn/read/202084>
2. 中国特色大国外交展现大国担当, [https://www.chinanews.com.cn/gn/2021/05-29/9488240.shtml?utm\\_source=pocket\\_mylist/](https://www.chinanews.com.cn/gn/2021/05-29/9488240.shtml?utm_source=pocket_mylist/)
3. Хятад, Монгол хоёр улс сэргэн мандалтын замд хатуу хүтүүг хамтран давна, <http://itoim.mn/article/uROQt/29777/>
4. 疫情下 一带一路 “五通” 逆风前行, <http://www.chinatradenews.com.cn/content/202103/18/c129269.html>
5. 白皮书: 共建 “一带一路” 使相关国家760万人摆脱极端贫, <http://fec.mofcom.gov.cn/article/fwydy1/zgzx/202104/20210403051302.shtml>
6. Хятад улс “Бүс ба зам” санаачилга дэвшүүлэх болсон түүхэн нөхцөл, бодлогын шийдвэр ба хэрэгжилт, <http://www.mglnews.mn/content/read/82025.htm?fbclid=IwAR3Is9obCYohGb-6kaHNo8a9nblqPXaDRIWCBdRUUyvRWoWBZDaWM6Vx3Urg>
7. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, <https://mfa.gov.mn/trade/61577>
8. 2021年7月28日外交部发言人赵立坚主持例行记者会, [https://www.fmprc.gov.cn/web/wjdt\\_674879/zcjd/202107/t20210728\\_9180743.shtml](https://www.fmprc.gov.cn/web/wjdt_674879/zcjd/202107/t20210728_9180743.shtml)
9. Монгол, Хятадын харилцаа таатай үедээ хөгжиж байна, <https://news.mn/r/2418520/>
10. 30 мянган хонины хариуд Хубэй мужаас PCR оношлогооны төхөөрөмж, оношлуур бэлэглэв, <https://gogo.mn/r/dkgnn/>

11. 新时代的中国国际发展合作白皮书(全文) ,  
<http://www.scio.gov.cn/zfbps/32832/Document/1696685/1696685.htm>
12. БНХАУ-ын Засгийн газрын тусламжаар хэрэгжүүлэх Мазаалай баавгайн төслийн ажлын уулзалтын протоколд гарын үсэг зурлаа,  
[http://mn.china-embassy.org/mn/zmgx/201610/t20161012\\_1661457.htm](http://mn.china-embassy.org/mn/zmgx/201610/t20161012_1661457.htm)

## China's New Foreign Policy since 18<sup>th</sup> Party Congress and Mongolia-China Relations

***Chuluun-Erdene Terbish***

*Ph.D, lecturer University of Humanities,*

*Ulaanbaatar, Mongolia*

*chuluunerdene.t@gmail.com*

***Abstracts:*** *Since the 18th National Congress of the Communist Party of China (CPC), the CPC has entered a new stage of innovation in diplomatic theory and practice, forming Xi Jinping Thought on Diplomacy, which will continue to guide China's major-country diplomacy in the new era. The new diplomatic strategy of the new Chinese government led by Xi Jinping has three features. First, it hopes to actively build a new model of major-country relations. Second, it hopes to build a "destiny community of neighboring countries" diplomacy. Third, to look forward to building a new type of international relations in which win-win cooperation is the top priority of their foreign policy. In this article, I will introduce the new foreign policy adopted by China since the 18th National Congress of the Communist Party of China and the neighborhood diplomacy featuring amity, sincerity, mutual benefit and inclusiveness. In addition, it also describes the diplomatic relations between Mongolia and China from 2012 to 2021 and important events within the scope of cooperation between the two countries, especially the friendly stories of mutual support and assistance between China and Mongolia after the outbreak of COVID-19.*

***Keywords:*** *China new foreign policy, Shi Jinping, 18<sup>th</sup> Congress, destiny community of neighboring countries, Mongolia-China relations*

*The day of submission:* 2021.12.15

*Completion of review:* 2021.12.22

*Final decision for acceptance:* 2021.12.29